



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/329

Улаанбаатар хот


Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монголын нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.

2. Ёс зүйн дүрмийг нийт нийгмийн ажилтнуудад сурталчлан, мөрдүүлж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /О.Алтансүх/, Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/ нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжлийн газар /С.Тунгалагтамир/, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/ нарт даалгасугай



Н.НОМТОЙБАЯР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-
ны өдрийн А/329 тоот тушаалын
хавсралт

МОНГОЛЫН НИЙГМИЙН АЖИЛТНЫ МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү ёс зүйн дүрэм¹ нь /цаашид “дүрэм” гэх/ нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ, үйл ажиллагаанд баримтлах үнэт зүйлс, зарчим, үйлчилгээ үзүүлэх явцад мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, үүрэг хариуцлагыг тогтоох, ёс зүйн дүрэм зөрчигдсэн эсэх талаар дүгнэлт гаргах, хүлээлгэх хариуцлагыг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Нийгмийн ажилтан нийгмийн ажлын олон талт үйлчилгээг хүргэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль Нийгмийн халамжийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль болон олон улсын гэрээ конвенци, бусад холбогдох ёс зүйн хэм хэмжээг тогтоосон эрх зүйн актыг удирдлага болгоно.

Хоёр. Хамрах хүрээ

2.2. Энэхүү дүрэм нь хөдөлмөр, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах, нийгмийн хөгжил, хүний эрхийг хангах зэрэг нийгмийн бүх салбарт ажиллаж, мэргэжлийн шууд ба шууд бус үйлчилгээг үзүүлж байгаа нийгмийн ажилтан, нийгмийн ажил үйлчилгээний чиглэлээр эрдэм, шинжилгээ, судалгаа, арга зүйн ажил эрхэлдэг багш, судлаач, нийгмийн ажлын мэргэжлийн нийгэмлэгт хамаарна.

Гурав. Нийгмийн ажлын үнэт зүйлс, зарчмууд

3.1. Нийгмийн ажилтан нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаа, үйлчилгээнд дараах үнэт зүйлсийг баримтлана.

- 3.1.1. хүний эрх, нэр төрийг хүндэтгэх;
- 3.1.2. нийгмийн шударга ёсны төлөө тэмцэх;
- 3.1.3. хувь хүний болон нийгмийн сайн сайхны төлөө үйлчлэх;
- 3.1.4. мэргэжлийн мэдлэг, ур чадвар, зохих хандлагыг эзэмшсэн байх;

3.2. Нийгмийн ажилтан 3.1.1-т заасан хүний эрх, нэр төрийг хүндэтгэх үнэт зүйлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

¹Анх 2006 онд энэ дүрмийн төслийг боловсруулах ажлын санаачлагыг Нийгмийн ажлын хөгжлийн төв, Их Британий Хүүхдийг ивээх сан, Соросын Сангийн тэтгэлэгээр нийгмийн ажлын магистрийн хөтөлбөрийн АНУ-ын Пеннсилваний их сургууль, Колумбийн их сургууль, Сант-Луйс дахь Вашингтоны их сургуулиудад дүүргэсэн хэсэг нөхөд гаргаж, анхны дүрмийн төслийг нийгмийн ажлын чиглэлээр сургалт явуулдаг их дээд сургуулийн багш нартай хамтран боловсруулсан. 2006 оны 12-р сарын 26-нд энэхүү дүрмийн төслийн анхны хувилбарыг Нийгмийн ажилтнуудын зөвлөгөөнөөр сайшаан баталсан. 2012 оны 12-р сарын 24-нд Норвегийн тусламжийн байгууллагын дэмжлэгээр дүрмийн төслийг сайжруулж эцэслэх ажлыг Нийгмийн ажлын багш сурагчдын холбооноос зохион байгуулж дүрмийн төслийг талаар бүх салбарын төрийн яамууд, агентлагууд болон МУ-ын Төрийн албаны зөвлөлөөс санал авсан. Түүнээс хойш 2013, 2016 онуудад нийгмийн ажлын багш судлаач, практикийн ажилтнуудын дунд энэ төсөл нь хэд хэдэн дахин хэлэлцэгдсэн болно.

3.2.1. хувь хүний нэр төр давтагдашгүй байдлыг хүндэтгэх;

3.2.2. хувь хүний өөрийгөө тодорхойлох эрхийг хүндэтгэн үйлчлүүлэгчийн хүсэл, сонирхол, үйлдэл нь бусад хүний эрх болон хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй тохиолдолд үйлчлүүлэгчийг өөрөө бие дааж сонголт хийх, шийдвэр гаргах боломжоор хангах;

3.2.3. үйлчлүүлэгчийн нийгэм, соёлын болон бусад ялгаатай байдлыг хүндэтгэх;

3.3. Нийгмийн ажилтан 3.1.2-т заасан нийгмийн шударга ёсны төлөө тэмцэх үнэт зүйлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

3.3.1. хувь хүний нас, хүйс, үндэс, угсаа, арьсны өнгө, соёлын онцлог, нийгэм эдийн засгийн болон гэр бүлийн байдал, улс төрийн үзэл бодол, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэг зэрэг аливаа асуудлаар ялгаварлан гадуурхахгүй байх;

3.3.2. хувь хүн, бүлэг, олон нийтийн нийгмийн амьдралд оролцох оролцоог дэмжин ажиллах;

3.3.3. нийгмийн шударга ёсыг хэрэгжүүлэхэд саад болж буй хүчин зүйлийг багасгах, нийгмийн гишүүдийн нөөц боломж, сонголтыг өргөжүүлэхийн төлөө ажиллах;

3.3.4. нийгмийн баялаг/нөөцийг шударга хуваарилах, ялангуяа нийгмийн баялгаас хүртэх боломж хязгаарлагдмал байгаа бүлгүүдийн аж байдлыг сайжруулахын төлөө ажиллах;

3.3.5. шударга бус, тэгш бус байдлыг бий болгож байгаа нийгмийн бүтцийг өөрчлөхийн төлөө ажиллах;

3.3.6. хүний эрхийн зөрчилтэй тэмцэх;

3.4. Нийгмийн ажилтан 3.1.3-т заасан хувь хүний ба нийгмийн сайн сайхны төлөө үйлчлэх мэргэжлийн үнэт зүйлсийг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

3.4.1. үйлчлүүлэгчдийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих;

3.4.2. үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээллийн нууцыг чанд хадгалах;

3.4.3. Үйлчилгээг үйлчлүүлэгчийн оролцоог хангасан, идэвхижүүлсэн, тэдний соёлын онцлогт тохирсон байдлаар зохион байгуулах;

3.5. Нийгмийн ажилтан 3.1.4-т заасан мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшсэн байх үнэт зүйлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

3.5.1. үйлчлүүлэгчийг чанартай үйлчилгээгээр хангахын тулд өөрийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлагыг байнга хөгжүүлэх;

3.5.2. мэргэжил нэгт нөхдөө дэмжиж, харилцан мэдээлэл, туршлага солилцох;

3.5.3. нийгмийн асуудлууд, нийгмийн ажлын хэрэгцээг цаг тухайд нь танин мэдэж, шийдвэрлэх арга зам, стратегийг боловсруулахад хувь нэмэр оруулах;

3.5.4. нийгмийн бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгохын төлөө ажиллах;

3.5.5. нийгмийн ажлын сургалт, судалгаа, үйл ажиллагаа, мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгоход мэргэжлийн хувь нэмэр оруулах;

3.5.6. удирдлагадаа ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудын ёс зүй, үйлчилгээний чанарт хяналт тавих;

Дөрөв. Нийгмийн ажилтны ёс зүйн хэм хэмжээ

4.1. Нийгмийн ажилтан нь хүний эрх ба хувь хүний эрхэм чанарыг дээдлэж, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд аюул учруулахгүй байх, үйлчлүүлэгчид өөрөө бие дааж сонголт хийх, шийдвэр гаргах боломж олгогдоход ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллана.

4.1.1. Нийгмийн ажилтан хүн бүрийн өөрийгөө тодорхойлох эрхийг хүндэтгэхэд дараах ёс зүйн хэм хэмжээг мөрдөнө. Үүнд:

4.1.1.1. үйлчилгээг үзүүлэхээс өмнө үйлчлүүлэгчдээ ямар үйлчилгээ авах боломж байгааг ойлгуулсан байна.

4.1.1.2. үйлчлүүлэгчдээ үзүүлэх үйлчилгээний хэлбэр, үргэлжлэх хугацаа, ямар нэг хязгаарлалт, сул тал байгаа эсэхийг тайлбарлаж ойлгуулан, тэмдэглэл хөтлөнө.

4.1.2. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгч бүрийн давуу тал, нөөц чадавхид тулгуурлан тэднийг үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад оролцох боломжоор хангах хүрээнд дараах хэм хэмжээг мөрдөнө. Үүнд:

4.1.2.1. үйлчилгээний хувилбараас сонголт хийхэд нь туслах, үйлчлүүлэгч албадлагаар үйлчилгээ авах шаардлагатай тохиолдолд үйлчилгээний журам, үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөг сайтар танилцуулж ойлгуулна.

4.1.2.2. үйлчлүүлэгч бүрт үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулах ба төлөвлөгөө нь үйлчилгээний төрөл, зорилго, хүлээгдэж буй үр дүн, арга зам, үйлчилгээг сонгосон шалтгаан зэргийг агуулсан байна.

4.1.2.3. дүрмийн 4.1.2.2-т заасан төлөвлөгөөг тодорхой хугацаанд шинэчилнэ.

4.2. Нийгмийн ажилтан нь хувь хүнийг түүний орчинтой нь цогц байдлаар авч үзэх ба үйлчлүүлэгчийн амьдралын бүх хүрээг хамруулан авч үзнэ.

4.3. Нийгмийн ажилтан нь хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтийн давуу талыг олж илрүүлэн, тэдний давуу талыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, чадваржуулахад анхаарч ажиллах ба үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, тулгарч буй эрсдлийг үнэлэхдээ дараах хүрээг хамруулан авч үзнэ. Үүнд:

4.3.1. үйлчлүүлэгчийн нийгэм-сэтгэл зүй, биологи ба бүтцийн онцлог, хөгжлийн үе шатуудын тухай мэдлэг, мэдээллийг тухайн үйлчлүүлэгчийн нөхцөл байдалтай холбон судална.

4.3.2. үйлчлүүлэгчид тулгарах аливаа эрсдлийг үйлчлүүлэгч ба оролцогч талуудын зан үйл, орчны хүчин зүйлс, бусад эрсдэлтэй холбон судална.

4.3.3. үйлчлүүлэгчид тулгарч буй асуудлын нийгмийн бүтэц, хүчин зүйлстэй холбон тодорхойлно.

4.3.4. нийгмийн тогтолцооны нөлөө болох хууль эрх зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын зүгээс үйлчлүүлэгчид үзүүлэх нөлөөг харгалзан үзнэ.

4.3.5. үйлчлүүлэгчийн давуу тал, нөөц боломжийг илрүүлнэ.

4.3.6. үйлчлүүлэгчид тохиолдож байгаа эрсдэлтэй нөхцөл байдлын түвшинг үнэлж, түүнийг багасгах арга хэмжээ авна.

4.4. Нийгмийн ажилтан нь нийгмийн шударга ёсыг дэмжин, нийгмийн бүх хүрээнд шударга ёсыг хангахын төлөө ажиллаж, дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

4.4.1. авъяас чадвар, нас, соёлын онцлог, хүйс, гэр бүлийн байдал, нийгэм эдийн засгийн байдал, улс төрийн үзэл бодол, арьсны өнгө, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэг зэрэг ялгаатай байдлыг үндэслэн хэн нэгнийг ялгаварлан гадуурхах явдлыг эсэргүүцнэ.

4.4.2. үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ хувь хүн, гэр бүл, бүлгийн болон нийгмийн ялгаатай байдлыг харгалзан тэдний соёл, зан суртахууны ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч хүндэтгэн үзнэ.

4.4.3. өөрийн мэдэлд байгаа нөөцийг шударга хуваарилна.

4.4.4. нийгмийн хүрээнд төлөвлөсөн хөрөнгө, санхүүжилт шаардлага хангахгүй байгаа болон түүнийг хуваарилах талаар явуулж буй бодлого, үйл ажиллагаа нь шударга бус, нэг талыг хэт барьсан, муу үр дүнтэй байгаа үед эрх баригчид, улс төрчид, албан тушаалтнууд болон өргөн олон нийтийн анхаарлыг түүнд хандуулж, шудрага бус бодлого, үйл ажиллагаатай тэмцэж, засаж сайжруулахын төлөө ажиллана.

4.4.5. үйлчлүүлэгчийн нийгэм сэтгэлзүйн орчинд бүхлээр нь хандсан үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлж, хүмүүсийг нийгмийн гарал, үндэс угсаа, соёлын онцлогоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, захиран тушааж, ялгаатай байдал үүсгэхгүй байх, нийгмийн нөхцөл байдалд анхаарлаа хандуулж, эв нэгдлийг хангах үйл ажиллагаа явуулна.

4.5. Нийгмийн ажилтан нь өөрийн мэдлэг, ур чадварыг байнга хөгжүүлнэ.

4.5.1. нийгмийн ажилтан нь өөрийн үйл ажиллагаанд зайлшгүй хэрэгтэй мэргэжлийн мэдлэг, чадвар, дадал эзэмшиж, түүнийгээ байнга хөгжүүлнэ.

4.5.2. нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчийн нөхцөл байдлыг үнэлэх, чанартай үйлчилгээ хүргэх, үнэлгээнд үндэслэн өөр байгууллага руу шилжүүлэх талаар мэдлэг, чадвартай байна.

4.6. Нийгмийн ажилтан нь ажил үүргээ шударга үнэнч биелүүлнэ.

4.6.1. нийгмийн ажилтан нь өндөр мэдлэг, ур чадвартай ирээдүйн нийгмийн ажилтныг бэлтгэхэд хувь нэмрээ оруулж, нийгмийн ажлын ангийн оюутныг дадлагажуулах, сургах чиглэлээр нийгмийн ажилтан бэлтгэдэг их дээд сургуулиудтай хамтран ажиллана.

4.6.2. нийгмийн ажилтан нь хийж гүйцэтгэсэн ажлынхаа төлөө өөрийн үйлчлүүлэгч, хамтран зүтгэгчид, ажил олгогч, мэргэжлийн холбоод болон хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.

Тав. Нийгмийн ажилтны үйл ажиллагаанд хориглох зүйл

5.1. Нийгмийн ажилтны үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно. Үүнд:

5.1.1. үйлчилгээ үзүүлснийхээ төлөө үйлчлүүлэгчээс шагнал, урамшуулал, бэлэг, дурсгал авах;

5.1.2. мэргэжлийн мэдлэг, ур чадвараа хүмүүнлэг бус үйл ажиллагаанд ашиглах;

5.1.3. үйлчлүүлэгчийнхээ ашиг сонирхол ба хэрэгцээг өөрийн ашиг сонирхол ба хэрэгцээнд захируулан ашиглах;

5.1.4. үйлчлүүлэгчид хандахдаа сонирхлын зөрчил, бэлгийн дарамт, бэлгийн болон хувийн зохисгүй харилцаа гаргах;

5.1.5. үйлчлүүлэгчийн итгэл найдварыг буруугаар ашиглах, өөрийн байр сууриа хувийн зорилгод ашиглах;

5.1.6. ажил, мэргэжлийн шаардлагаар олж авсан мэдээллийг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүй бусадтай хуваалцах, нэр төр, эрх ашгийг нь хөндөх, хохироох;

Зургаа. Нийгмийн ажилтны баримтлах мэргэжлийн ёс зүйн үүрэг, хариуцлага

6.1. Нийгмийн ажилтан мэргэжлийн үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлж байхдаа үйлчлүүлэгч, нийгмийн үйлчилгээний байгууллага, мэргэжил нэг нөхөд, нийгмийн өмнө хариуцлага хүлээнэ.

6.2. Нийгмийн ажилтан энэ дүрмийн 6.1-т дурдсан үйлчлүүлэгчийн өмнө дараах үүрэг, хариуцлага хүлээнэ. Үүнд:

6.2.1. хувь хүний онцлогийг харгалзан үйлчлүүлэгчтэй харилцана.

6.2.2. үйлчлүүлэгчийн хүсэл сонирхлыг хүндэтгэн үзэж, үйлчлүүлэгчийн сайн сайхан байдлыг хангахын төлөө ажиллана.

6.2.3. үйлчлүүлэгч үйлчилгээг сонгох болон өөрийн амьдралаа тодорхойлох эрхийг нь дэмжинэ.

6.2.4. үйлчлүүлэгчийн хувийн амьдрал, эрхэм чанарыг нь хүндэтгэнэ.

6.2.5. үйлчлүүлэгчийн оролцож байгаа нийгмийн ажлын үйлчилгээ, судалгаа ба үйл ажиллагааны талаар үйлчлүүлэгчид ойлгомжтой, тодорхой хэлбэрээр танилцуулж, үйлчлүүлэгчид бүрэн мэдээлэлтэй, сонголт хийх эрхтэйгээр үйлчилгээнд оролцох боломж олгоно.

6.2.6. нийгмийн ажлын төрөл бүрийн үйлчилгээ авах, нийгмийн баялгаас хүртэх, мэдээллээр хангагдах зэрэг нийгмийн үйлчилгээний бүхий л шатанд үйлчлүүлэгч тэгш оролцох боломжоор хангахын төлөө ажиллана.

6.2.7. үйлчлүүлэгчид чиглэсэн аливаа үйлчилгээг нийгмийн ажлын үнэт зүйлс, мэдлэг, ур чадвар, шинжлэх ухааны баримт нотолгоон дээр тулгуурлан үзүүлнэ.

6.2.8. үйлчлүүлэгчийн соёл, үнэт зүйлд хүндэтгэлтэй хандаж, хүмүүсийн ялгаатай байдлыг ойлгон үйлчилгээг хүргэнэ.

6.2.9. нийгмийн ажлын үйлчилгээ эхлэхээс дуусах хүртэлх бүх шатанд үйлчлүүлэгчийн хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн мэргэжлийн түвшинд үйлчилгээг хүргэнэ.

6.3. Нийгмийн ажилтан энэ дүрмийн 6.1-т дурдсан нийгмийн үйлчилгээний байгууллагын өмнө дараах үүрэг, хариуцлага хүлээнэ. Үүнд:

6.3.1. нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн зарчимд нийцэхүйц үйлчилгээ, мэргэжлийн үйл ажиллагааг дэмжих бодлого, журам арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байгууллагатай хамтран ажиллана.

6.3.2. байгууллагын үүрэг даалгавар, зорилгыг хариуцлагатайгаар гүйцэтгэнэ.

6.3.3. зөв зохистой бодлого, журам, үйл ажиллагааг хөгжүүлэх, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгоход байгууллагадаа хувь нэмэр оруулахыг зорино.

6.3.4. байгууллагын үйлчилгээ, түүний чанарт байнга хяналт тавих замаар нийгмийн ажилтнуудын үйл ажиллагааны эцсийн үр дүнг баталгаажуулж, нийгэм, үйлчлүүлэгчдийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагыг өндөржүүлнэ.

6.3.5. байгууллагын бодлого, журам, хэвшмэл үйл ажиллагаа нь нийгмийн ажлын ёс зүйн зарчмуудтай илт зөрчилдөж буй тохиолдолд ёс зүйд нийцэх бүх арга замаар асуудлыг шийдэхийг зорино.

6.3.6. нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажилллаганд бэрхшээл учруулах хувийн шинжтэй асуудлыг удирдлагадаа мэдээлнэ.

6.4. Нийгмийн ажилтан энэ дүрмийн 6.1-т дурдсан мэргэжил нэг нөхдийн өмнө дараах үүрэг, хариуцлага хүлээнэ.

6.4.1. мэргэжлийн нийгмийн ажилтны боловсрол, дадлага туршлага, чадварыг үнэлж хүндэтгэх, тэдгээрийн үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх бүх талын дэмжлэг, туслалцааг үзүүлнэ.

6.4.2. нийгмийн ажилтнууд болон мэргэжлийн хүмүүсийн хоорондын үзэл бодол, үйл ажиллагааны онцлог, ялгааг хүлээн зөвшөөрч, шүүмжлэлийг тодорхой ойлгомжтой илэрхийлнэ.

6.4.3. бусад мэргэжлийн ажилтан, сайн дурын ажилтантай хамтран ажиллаж, төрөл бүрийн боломж, бололцоог хуваалцах, мэдээлэл, туршлага солилцох, нээлттэй хамтран ажиллана.

6.4.4. мэргэжлийн ёс зүйн болон бусад хэм хэмжээг зөрчсөн үзэгдлийг холбогдох байгууллага, үйлчлүүлэгчдэд зохих ёсоор мэдэгдэнэ.

6.4.5. мэргэжил нэгт нөхдөө шударга бус үйлдлээс хамгаална.

6.5. Нийгмийн ажилтан энэ дүрмийн 6.1-т дурдсан нийгмийн өмнө дараах үүрэг, хариуцлага хүлээнэ.

6.5.1. нийгмийн өмнө мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүйн зарчим, мэдлэг, арга барилыг баримталж, тэдгээрийг тодотгох, сайжруулах талаар анхаарч ажиллана.

6.5.2. өөрийн мэргэжлийг шударга бус шүүмжлэлээс хамгаалж, нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай гэдэг итгэлийг баталгаажуулах талаар чармайн ажиллана.

6.5.5. нийгмийн ажил, мэргэжлийн онол, арга зүйн талаар бүтээлчээр санал дэвшүүлнэ.

6.5.6. нийгмийн бодит байдал, шинээр гарч буй хэрэгцээ шаардлагыг шийдвэрлэх, арга зүйг дэмжин нэвтрүүлнэ.

Долоо. Монголын нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн үндэсний болон салбар хороо

7.1. Дүрмийг хэрэгжүүлэх, хяналт тавих асуудлаар Монголын нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн бие даасан үндэсний хороо /цаашид үндэсний хороо гэх/-г байгуулан ажиллуулна.

7.2. Үндэсний хороо нь салбар хороодтой байх ба салбар хороог аймаг, нийслэл, дүүргийн түвшинд байгуулан ажиллуулна.

7.3. Үндэсний болон салбар хороо нь үйл ажиллагааны дүрэмтэй байх ба дүрмээ өөрөө батална.

7.4. Ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдлыг салбар хороо хүлээн авч, ёс зүй зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргах ба шаардлагатай тохиолдолд үндэсний хороонд уламжилна.

7.5. Үндэсний хороо ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар шинжээч томилж дүгнэлт гаргуулна. Шинжээчийг үндэсний хорооны дарга гишүүдээс томилж ажиллуулна.

7.6. Үндэсний болон салбар хороо нь ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээнэ.

7.7. Үндэсний болон салбар хороо нь энэ дүрмийн 7.6-д дурдсан үүргээс гадна дүрмийг Засгийн газрын байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, нийгмийн ажилтнууд, холбогдох байгууллагуудад түгээн, дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.

7.8. Ёс зүйн дүрэмд заагдаагүй асуудлыг үндэсний болон салбар хороогоор хэлэлцэх тохиолдолд Нийгмийн ажилтны олон улсын ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө.

7.9. Үндэсний болон салбар хорооны бүтэц, зохион байгуулалт

7.9.1. Үндэсний хороо нь 15 гишүүнтэй байх ба бүрэлдэхүүнд хөдөлмөр, нийгмийн хамгаалал, боловсрол соёл шинжлэх ухаан, спорт, хууль зүй, дотоод хэрэг, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох албан тушаалтан, нийгмийн ажилтан бэлтгэдэг их дээд сургууль, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, анхан шатанд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж байгаа Нийгмийн ажилтны төлөөлөл багтана.

7.9.2. төрийн захиргааны төв байгууллагын холбогдох албан тушаалтнаас бусад үндэсний хорооны гишүүд сонгон шалгаруулалтын дагуу Үндэсний хорооны гишүүн болно.

7.9.3. Салбар хороо нь 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байх ба гишүүнээр нийгмийн ажилтан ажиллаж буй салбарын асуудал хариуцсан холбогдох албан тушаалтан, анхан шатны нийгмийн ажилтнууд ажиллана.

7.9.4. Үндэсний хорооны гишүүнээр Нийгмийн ажлын мэргэжлээр бакалавраас доошгүй зэрэгтэй, мэргэжлээрээ 5-с доошгүй жил ажилласан туршлагатай байх шаардлагыг хангасан байна.

7.9.5. Үндэсний хорооны гишүүд дотроосоо нэг гишүүнээ тэргүүнээр сонгоно.

7.9.6. Үндэсний хорооны гишүүнийг гурван жил тутамд шинэчилж сонгоно. Сонгон шалгаруулах гишүүний 30 хүртэлх хувийн гишүүн нэг удаа улиран сонгогдож болно.

7.9.7. Үндэсний хорооны гишүүн сонгон шалгаруулах ажлыг үндэсний хорооноос томилсон ажлын хэсэг зохион байгуулна.

Найм. Ёс зүйн дүрэм зөрчигчид хүлээлгэх хариуцлага

8.2. Ёс зүйн хорооны дүгнэлт нь хууль, тогтоомж, байгууллагын дүрэмд заасан сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл байж болно.

-----oO-----